ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn
2016.02.25 № 189
танай ________-ны № ________-т

УЛААНБААТАР ХОТЫН
ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,
ТУСЛАХ КОМИССАР
Ч.БОЛДБААТАР ТАНАА

# АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газраас аудит хийв.

Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн аудитын газар нь Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

## Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

1110400189

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Улаанбаатар хотын Цагдаагийн хэлтсийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ОЧИРБАТ

D:\2016 on\yavuulsan bichig\2016.02.25 UB Tsagdaad Gerchilgee.docx

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2016 оны 02 сарын 29 өдөр Дугаар 01/29 Улаанбаатар хот

НӨГ- 2016/ 487/ СТА — 723

## ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Цагдаагийн газрын 2015 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. **Алба хаагчдад ажлын үр дүнгийн шагнал урамшууллыг 233,634.2 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь давтан гарсан зөрчил бөгөөд өмнөх аудитын зөвлөмж, албан шаардлага хэрэгжээгүй байна. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт оруулсан "*үндсэн цалин*" гэсэн тодорхойлолтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1, 48.3, 48.3, 50.1; Төрийн албаны тухай хуулийн 31.1, 31.2, 31.3 дугаар зүйл, Засгийн Газрын 1995 оны 96 дугаар тогтоол;**

2. **Алба хаагчдад ээлжийн амралтын олговрыг 319.4 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан "*Ээлжийн амралт тооцох журам*"-ын 3, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "*Дундаж цалин хөлс тодорхойлох журам*"-ын 4 дэх заалтуудыг;**

3. Шийтгэвэр, торгуулийн орлогын 43,655.0 мянган төгрөгийг 4-345 хоногоор хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан нь Сангийн сайдын 1992 оны 112 дугаар тушаалаар баталсан Шийтгэвэр торгуулийн хуудас түүнийг хэрэглэх зааварт "*Торгууль ногдуулж төлүүлсэн албан тушаалтан торгуулын мөнгийг 3 хоногийг дотор байгууллагынхаа дансанд /касст/ тушааж, тухай бүр тооцоо хийнэ*" заалт, "*Шийтгэврээр төлөх торгуулийг 15 хоногийн дотор төлөөгүй албан тушаалтан, хувь хүн байгууллагаас уг мөнгийг шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар гаргуулан авна*" заалтуудыг;

4. Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цагдаагийн хэсгийн 2 давхар конторын барилгын 50 хувийг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад ашиглуулсан ч түрээсийн гэрээ байгуулаагүй орлого тооцдоггүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28. 2-д "*Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ.*" заалтыг;

5. Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн балансад бүртгэлтэй 4,878.7 мянган төгрөгийн хашаа, агуулах, вагончикийг бусдад ашиглуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д "*Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын*

1110400039

*зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно*" заалтыг зөрчиж, байгууллагын эзэмшил хяналтаас гадна байна.

6. Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1,147.3 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1. "*Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно*", 1.7. " *Анхан шатны баримт бүрдүүлээгүй ... байхыг* " заалтыг;

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-ийн *"Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж байгаа аудитын дүнд шалгагдагч байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлэх нь тухайн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байхад чухал үр нөлөөтэй гэж үзсэн дараах алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө"* заалтыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Дээд шатны байгууллагад асуудлыг тавьж бусад холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэн шийдвэрлүүлэх;
2. Цалингийн нэмэгдэл болон ээлжийн амралтыг илүү тооцон олгохгүй байх;
3. Шийтгэвэр, торгуулийн хуудасны зарцуулалтанд хяналт тавьж, орлогыг тухай бүрд төсөвт төвлөрүүлж байх;
4. Хөрөнгөнд тавих дотоод хяналтыг сайжруулах, өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулахгүй байх;
5. Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг үндэслэн гүйлгээ хийж байх;

Дээрх алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй ажиллах, албан шаардлагын хэрэгжилт, үр дүнг Нийслэлийн аудитын газарт 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан хариу ирүүлэхийг шаардаж байна.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

| | |
|---|---|
| АХЛАХ АУДИТОР | Д.ЖАРГАЛСАЙХАН |
| АУДИТОР | Б.ДОЛГОРСҮРЭН |
| АУДИТОР | Б.ТЭГШЛХАМ |

**ХЯНАСАН:**

| | |
|---|---|
| ДЭД ДАРГА | Я.САМБУУНЯМ |
| САНХҮҮГИЙН АУДИТЫН АЛБАНЫ АУДИТЫН МЕНЕЖЕР | Д.ЭНХДАЛАЙ |

ТАБ-СТА-В-4

## 2015 оны аудитаар илэрсэн асуудлын бүртгэл

**Байгууллагын нэр:** Нийслэлийн Цагдаагийн газар харьяа хэлтсүүд

**Тайлант огноо:** 2015 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

| № | Сорил хийсэн дансны нэр | Аудитаар илэрсэн асуудал | Зөрчлийн дүн | Санхүүгийн тайланд үзүүлэх нөлөө (материаллаг, материаллаг бус) | Аудиторын санал (Бүртгэлийн бичилт, тооцоолол) | Тухайн байгууллагын санал ( Бүртгэлийн бичилт, тооцоолол) | Уулзалтын үр дүнгийн баталгаажуулалт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үнэт цаас | Шийтгэвэр, торгуулийн орлогын 43,655.0 мянган төгрөгийг 4-345 хоногоор хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан нь Сангийн сайдын 1992 оны 112 дугаар тушаалаар баталсан Шийтгэвэр торгуулийн хуудас түүнийг хэрэглэх зааварт *"Торгууль ногдуулж төлүүлсэн албан тушаалтан торгуулын мөнгийг 3 хоногийг дотор байгууллагынхаа дансанд /касст/ тушааж, тухай бүр тооцоо хийнэ"* заалт, *"Шийтгэвэрээр төлөх торгуулийг 15 хоногийн дотор төлөөгүй албан тушаалтан, хувь хүн байгууллагаас уг мөнгийг шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар гаргуулан авна"* заалтуудыг зөрчсөн. | 43,655.0 | материаллаг бус | Шийтгэвэр, торгуулийн хуудасны зарцуулалтанд хяналт тавьж, төсвийн орлогыг хууль журамд заагдсан хугацаанд улсын төсөвт төвлөрүүлж байх | | |
| 2 | Цалингийн зардал | Алба хаагчдад ажлын үр дүнгээр олгосон шагнал урамшууллыг 233,634.2 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 31.1, 31.2, 31.3 дугаар зүйл, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал, урамшуулал олгох журам"-д заасан заалтыг зөрчсөн | 233,634.2 | материаллаг | Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, давтан гарсан зөрчил | | |
| 3 | Цалингийн зардал | Алба хаагчдад ээлжийн амралтын олговрыг 319.4 мянган төгрөгөөр илүү тооцон олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан *"Ээлжийн амралт тооцох журам"*-ын 3, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан *"Дундаж цалин хөлс тодорхойлох журам"*-ын 4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. | 319.4 | материаллаг бус | Ажлын үр дүнгээр тооцох шагнал урамшууллыг илүү олгохгүй байх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Үндсэн хөрөнгө | Сүхбаатар дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цагдаагийн хэсгийн 2 давхар конторын барилгын 50 хувийг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад ашиглуулсан ч түрээсийн гэрээ байгуулаагүй орлого тооцдоггүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28. 2-д *"Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ ."* | | материаллаг бус | Түрээсийн гэрээ байгуулж, өөрийн орлогыг нэмэгдүүлэх, албан шаардлага хүргүүллээ | | |
| 5 | Үндсэн хөрөнгө | Хан-Уул дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн балансад бүртгэлтэй 4,878.7 мянган төгрөгийн хашаа, агуулах, вагончикийг бусдад ашиглуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-д *"Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно"* заалтыг зөрчиж, байгууллагын эзэмшил хяналтаас гадна байна | 4,878.7 | материаллаг | Тооллогын үнэн зөв чанартай гүйцэтгэж ээнжүүлэх | | |
| 6 | Мөнгөн хөрөнгө | Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1,147.3 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1-д Нягтлан бодогчийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно: 1.7-д *"анхан шатны баримт бүрдүүлээгүй, заавал хөтлөх ёстой журнал, ерөнхий дэвтэр, дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтрийг хөтлөөгүй байх;"* заалтыг зөрчиж байна. | 1,147.3 | материаллаг бус | Анхан шатны хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгахгүй байх | | |
| 7 | Санхүүгийн тайлагнал | Орлого үр дүнгийн тайланд барьцааны мөнгөний 57,117.0 мянган төгрөгийг давхардуулан, хөрөнгийн гарзыг 430,718.4 мянган төгрөгөөр зөрүүлсэн, элэгдлийн зардал тооцогдохгүй батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмжид 3,375.0 мянган төгрөгийн элэгдэл тооцсон | 491,210.4 | материаллаг бус | Жилийн эцсийн санхүүгийн болон нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ыг мөрдөж ажиллах | | |
| 8 | Санхүүгийн тайлагнал | Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнг тодруулгын тайлангаас 225,276.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан; | 225,276.9 | материаллаг бус | | | |
| 9 | Санхүүгийн тайлагнал | Тушаалаар батлагдсан ор[illegible] тоо нь төсвийн гүйцэтгэлийн тайланд дахь төсөвлөгдсөн ажиллагсадын тооноос зөрүүтэй бичигдсэн; | | материаллаг бус | | | |
| 10 | Санхүүгийн тайлагнал | Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа тохируулга хийгээгүйгээс 3,593,530.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг давхардуулан буруу тайлагнасан; | 3,593,530.9 | материаллаг бус | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Санхүүгийн тайлагнал | Бараа материалд бүртгэлтэй мал амьтдын нас дэвшилтийг зах зээлийн үнэд нийцүүлэн үнэлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана*", Цагдаагийн ерөнхий газрын 2010 оны 131 дугаар тушаалын 2-т " Зах зээлийн ханш, үнийн өөрчлөлттэй холбогдуулан жил бүр малын үнийг тогтоож батлуулахыг ахлах мэргэжилтэнд даалгасугай." гэж заасан нь хэрэгжихгүй байна | | материаллага бус | Жилийн эцсийн санхүүгийн болон нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар"-ыг мөрдөж ажиллах | | |
| | | **Нийт дүн** | **4,593,652.8** | | | | |

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэл хөтөлсөн аудитор Б.Тэгшхам Огноо................

СА-1-1 багийн ахлах аудитор Д.Жаргалсайхан

Аудитор Г.Долгорсүрэн

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг зөвшөөрсөн

Байгууллагын дарга, цагдаагийн туслах комиссар Ч.Болдбаатар Огноо....11.29.

Санхүү хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч А/д Л.Батсүрэн Огноо................

Зөвшөөрөөгүй бол шалтгааныг бичнэ ........................................

**Анхан шатны хяналт хийсэн аудиторын менежер:** **Д.Энхдалай** Огноо................

**Аудитын менежерийн санал:** ........................................

**Хоёр дахь шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор** **Ц.Очирбат** Огноо................

**Тэргүүлэх аудиторын санал:** ........................................

## Нийслэлийн Цагдаагийн газрын 2015 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

2016.02.22

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн утга | Санхүүгийн тайлагнал | | | | | | | Мөнгөн хөрөнгө | Бараа материал | | Үндсэн хөрөнгө | Орлого | Зарлага | | Зөрчлийн нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Орлого үр дүнгийн тайланд тайлант онд үүсэн барьцааны дүнгээр орлого зарлагын дүнг давхардуулан бүртгэсэн | Нэгдсэн тайланд хөрөнгийн гаргыг зөрүүтэй тайлагнасан | Элэгдлийн зардал тооцогдохгүй батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмжид элэгдэл тооцсон | Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнг тодруулгын тайлангаас зөрүүтэй тайлагнасан | Тушаалаар батлагдсан орон тоо нь төсвийн гүйцэтгэлийн тайланд дахь төсөвлөгдсөн ажиллагсадын тооноос зөрүүтэй бичигдсэн | Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа тохируулга хийгээгүйгээс үнэ төлбөргүй хөрөнгийг давхардуулан буруу тайлагнасан | Бараа материалд бүртгэлтэй мал амьтдын нас дэвшилтийг зах зээлийн үнэд нийцүүлэн үнэлээгүй | Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн | Шийтгэвэр, торгуулийн орлогын мөнгийг 4-345 хоногоор хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан | Замын цагдаагийн газар нь сар бүр үнэт цаасны тайланг бичигдсэн шийтгэврийн тоогоор тайлагнадаггүй | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хашаа, агуулах, вагончикийг бусдад ашиглуулж байгаа | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цагдаагийн хэсгийн 2 давхар конторын барилгын 50 хувийг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад ашиглуулсан ч түрээсийн гэрээ байгуулаагүй/орлого тооцоогүй | Алба хаагчдад ажлын үр дүнгээр олгосон шагнал урамшууллыг илүү тооцон олгосон | Хоол унааны хөнгөлөлтийн мөнгийг дундаж цалинд тооцон оруулснаар зэлжийн амралтын олговрыг илүү олгосон | |
| 1 | Нийслэлийн Цагдаагийн Нэгдсэн тайлан | | 430,718.4 | | 225,276.9 | 1 | 3,593,530.9 | 1 | | | | | | | | 4,249,528.2 |
| 2 | Улаанбаатар хотын Цагдаа | 57,117.0 | 430,718.4 | 3,375.0 | | | | 1 | | 1,815.0 | | | | 3,018.7 | | 496,045.1 |
| 3 | Нийслэлийн Замын цагдаа | | | | | | | 1 | | | 1 | | | 10,301.8 | | 10,303.8 |
| 4 | СХД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | | | | | 7,903.4 | | 7,903.4 |
| 5 | СХД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 3,275.0 | | | | 6,869.6 | | 10,144.6 |
| 6 | СХД-ийн Цагдаа-3 | | | | | | | | | 3,055.0 | | | | 6,743.7 | | 9,798.7 |
| 7 | БГД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 2,275.0 | | | | 10,350.0 | | 12,625.0 |
| 8 | БГД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 630.0 | | | | 7,793.5 | | 8,423.5 |
| 5 | ЧД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 2,890.0 | | | | 30,846.1 | | 33,736.1 |
| 6 | ЧД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 2,780.0 | | | | 11,074.4 | | 13,854.4 |
| 6 | СБД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 6,190.0 | | | | 19,721.6 | | 25,911.6 |
| 7 | СБД-ийн Цагдаа-2 | | | | | | | | 1,147.3 | 3,810.0 | | | 1 | 18,818.7 | 319.4 | 24,096.4 |
| 7 | БЗД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 2,960.0 | | | | 21,347.8 | | 24,307.8 |
| 8 | БЗД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 4,780.0 | | | | 25,990.4 | | 30,770.4 |
| 8 | БЗД-ийн Цагдаа-3 | | | | | | | | | 6,935.0 | | | | 6,935.0 | | 13,870.0 |
| 9 | ХУД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 265.0 | | 4,878.7 | | 13,397.6 | | 18,541.3 |
| 9 | ХУД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 1,755.0 | | | | 8,927.7 | | 10,682.7 |
| 10 | БНД-ийн Цагдаа | | | | | | | | | 185.0 | | | | 13,741.8 | | 13,926.8 |
| 10 | НД-ийн Цагдаа | | | | | | | | | 25.0 | | | | 9,610.3 | | 9,635.3 |
| 11 | БХД-ийн Цагдаа | | | | | | | | | 30.0 | | | | 242.1 | | 272.1 |
| | **Дүн** | **57,117.0** | **861,436.8** | **3,375.0** | **225,276.9** | **1.0** | **3,593,530.9** | **3.0** | **1,147.3** | **43,655.0** | **1.0** | **4,878.7** | **1.0** | **233,634.2** | **319.4** | **5,024,377.2** |
| Үүнээс | **Залруулсан** | **57,117.0** | **861,436.8** | **3,375.0** | **225,276.9** | **1.0** | **3,593,530.9** | **3.0** | | | | | | | | - |
| | **Акт** | | | | | | | | | | | | | | | - |
| | **Албан шаардлага** | | | | | | | | **1,147.3** | **43,655.0** | **1.0** | **4,878.7** | **1.0** | **233,634.2** | **319.4** | **283,636.6** |

Гүйцэтгэсэн: СА-1-1

Ахлах аудитор Д.Жаргалсайхан

Аудитор Б.Тэгшлхам

Аудитор Г.Долгорсүрэн

Танилцаж, зөвшөөрсөн:

Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Л.Батсүрэн

Ахлах нягтлан бодогч Н.Оюунбаатар

# Нийслэлийн Цагдаагийн газрын 2015 оны жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл

2016.02.22

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн утга | Санхүүгийн тайлагнал | | | | | | | Мөнгөн хөрөнгө | Бараа материал | | Үндсэн хөрөнгө | Орлого | Зарлага | | Зөрчлийн нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Орлого үр дүнгийн тайланд тайлант онд үүссэн барьцааны дүнгээр орлого зарлагын дүнг давхардуулан бүртгэсэн | Нэгдсэн тайланд хөрөнгийн гарзыг зөрүүтэй тайлагнасан | Элэгдлийн зардал тооцогдохгүй батлан хамгаалахын зориулалттай тоног төхөөрөмжид элэгдэл тооцсон | Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан үндсэн хөрөнгийн дүнг тодруулгын тайлангаас зөрүүтэй тайлагнасан | Тушаалаар батлагдсан орон тоо нь төсвийн гүйцэтгэлийн тайланд дахь төсөвлөгдсөн ажиллагсадын тооноос зөрүүтэй бичигдсэн | Нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргахдаа тохируулга хийгээгүйгээс үнэ төлбөргүй хөрөнгийг давхардуулан буруу тайлагнасан | Бараа материалд бүртгэлтэй мал амьтдын нас дэвшилтийг зах зээлийн үнэд нийцүүлэн үнэлээгүй | Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн | Шийтгэвэр, торгуулийн орлогын мөнгийг 4-345 хоногоор хугацаа хоцроон харилцах дансанд тушаасан | Замын цагдаагийн газар нь сар бүр үнэт цаасны тайланг бичигдсэн шийтгэврийн тоогоор тайлагнадаггүй | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хашаа, агуулах, вагончикийг бусдад ашиглуулж байгаа | Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цагдаагийн хэсгийн 2 давхар конторын барилгын 50 хувийг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад ашиглуулсан ч түрээсийн гэрээ байгуулаагүй/орлого тооцоогүй | Алба хаагчдад ажлын үр дүнгээр олгосон шагнал урамшууллыг илүү тооцон олгосон | Хоол унааны хөнгөлөлтийн мөнгийг дундаж цалинд тооцон оруулснаар ээлжийн амралтын олговрыг илүү олгосон | |
| 1 | Нийслэлийн Цагдаагийн Нэгдсэн тайлан | | 430,718.4 | | 225,276.9 | 1 | 3,593,530.9 | 1 | | | | | | | | 4,249,528.2 |
| 2 | Улаанбаатар хотын Цагдаа | 57,117.0 | 430,718.4 | 3,375.0 | | | | | | | | | | | | |
| 3 | Нийслэлийн Замын цагдаа | | | | | | | 1 | | 1,815.0 | | | | 3,018.7 | | 496,045.1 |
| 4 | СХД-ийн Цагдаа-1 | | | | | | | 1 | | | 1 | | | 10,301.8 | | 10,303.8 |
| 5 | СХД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | | | | | 7,903.4 | | 7,903.4 |
| 6 | СХД-ийн Цагдаа-3 | | | | | | | | | 3,275.0 | | | | 6,869.6 | | 10,144.6 |
| 7 | БГД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 3,055.0 | | | | 6,743.7 | | 9,798.7 |
| 8 | БГД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 2,275.0 | | | | 10,350.0 | | 12,625.0 |
| 5 | ЧД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 630.0 | | | | 7,793.5 | | 8,423.5 |
| 6 | ЧД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 2,890.0 | | | | 30,846.1 | | 33,736.1 |
| 6 | СБД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 2,780.0 | | | | 11,074.4 | | 13,854.4 |
| 7 | СБД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 6,190.0 | | | | 19,721.6 | | 25,911.6 |
| 7 | БЗД-ийн Цагдаа-1 | | | | | | | | 1,147.3 | 3,810.0 | | | 1 | 18,818.7 | 319.4 | 24,096.4 |
| 8 | БЗД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 2,960.0 | | | | 21,347.8 | | 24,307.8 |
| 8 | БЗД-ийн Цагдаа-3 | | | | | | | | | 4,780.0 | | | | 25,990.4 | | 30,770.4 |
| 9 | ХУД-ийн Цагдаа-1 | | | | | | | | | 6,935.0 | | | | 6,935.0 | | 13,870.0 |
| 9 | ХУД-ийн Цагдаа-2 | | | | | | | | | 265.0 | | 4,878.7 | | 13,397.6 | | 18,541.3 |
| 10 | БНД-ийн Цагдаа | | | | | | | | | 1,755.0 | | | | 8,927.7 | | 10,682.7 |
| 10 | НД-ийн Цагдаа | | | | | | | | | 185.0 | | | | 13,741.8 | | 13,926.8 |
| 11 | БХД-ийн Цагдаа | | | | | | | | | 25.0 | | | | 9,610.3 | | 9,635.3 |
| | | | | | | | | | | 30.0 | | | | 242.1 | | 272.1 |
| | **Дүн** | **57,117.0** | **861,436.8** | **3,375.0** | **225,276.9** | **1.0** | **3,593,530.9** | **3.0** | **1,147.3** | **43,655.0** | **1.0** | **4,878.7** | **1.0** | **233,634.2** | **319.4** | **5,024,377.2** |
| **Үүнээс** | **Залруулсан** | **57,117.0** | **861,436.8** | **3,375.0** | **225,276.9** | **1.0** | **3,593,530.9** | **3.0** | | | | | | | | - |
| | **Акт** | | | | | | | | | | | | | | | - |
| | **Албан шаардлага** | | | | | | | | **1,147.3** | **43,655.0** | **1.0** | **4,878.7** | **1.0** | **233,634.2** | **319.4** | **283,636.6** |

Гүйцэтгэсэн: СА-1-1

Ахлах аудитор Д.Жаргалсайхан

Аудитор Б.Тэгшлхам

Аудитор Г.Долгорсүрэн

Танилцаж, зөвшөөрсөн:

Санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч Л.Батсүрэн

Ахлах нягтлан бодогч Н.Оюунбаатар